



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018. оны 02 сарын 05-ны
өдөр хүлээн авсан.

БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 10.

Улаанбаатар хот

Барилга байгууламжийн норм нормативын
баримт бичигт нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын сайдын 2005 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 52 дугаар тушаалаар баталсан “Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл” /БНБД 21-04-05/ барилгын норм ба дүрэмд 14 дүгээр хавсралт болгон “Гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл төлөвлөх барилга байгууламжийн жагсаалт”-ыг нэмэлт оруулсугай.
2. “Гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл төлөвлөх барилга байгууламжийн жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл” /БНБД 21-04-05/-д оруулах нэмэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж хэвлэн олшруулах, сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллахыг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ /Ц.Амарсанаа/-т даалгасугай.
4. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдүүд захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг хуульд заасны дагуу албан ёсоор мэдэгдэх, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д үүрэг болгосугай.



Барилга, хот байгуулалтын Сайдын 2018
оны ...**01** дүгээр сарын **18**-ны өдрийн
10-дугаар тушаалын хавсралт

**“БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЛ УНТРААХ АВТОМАТ
ТӨХӨӨРӨМЖ, ДОХИОЛЛЫН ХЭРЭГСЭЛ” /БНБД 21-04-05/-Д
НЭМЭЛТ ОРУУЛАХ**

“Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл” /БНБД 21-04-05/ барилгын норм ба дүрмийн 13 дугаар хавсралт /“Гар ажиллагаатай галын мэдээлэгчийг барилга ба өрөөнүүдийн зориулалтаас хамааруулж байрлуулах нь”/-ын дараа 14 дүгээр хавсралт “Гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл төлөвлөх барилга байгууламжийн жагсаалт”-ыг оруулах.

Хавсралт № 14

**Гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл
төлөвлөх барилга байгууламжийн жагсаалт**

Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж /ГУАТ/, гал мэдээллэх дохиоллын хэрэгслийн /ГМДХ/ зураг төсөл зохиох, угсралт, ашиглалт засвар үйлчилгээний ажилд энэхүү заавал биелүүлэх хавсралтыг дагаж мөрдөнө.

1. Ерөнхий хэсэг

1. Хавсралтад заагдсан барилга, байгууламж нь гал тэсвэршилтийн 1-р зэргийн бүсэд хамрагдсан хучилт ба хашлага бүтээцээр бүхэлдээ буюу нэг хэсэг нь хамгаалагдсан орон зайн төлөвлөлт (галын бүслэвч) бүхий хэсгийг хэлнэ.

2. Гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл заавал төлөвлөх хүснэгт 3-т заасан “өрөө тасалгааны талбайн норматив” үзүүлэлт нь 0.75 цагаас багагүй гал тэсвэршилттэй хашлага хийц (хамар хана EI45, хана, хучилт REI45) бүтээцээр тусгаарлагдсан барилга байгууламжийн талбай гэж тооцож үзнэ.

Хэрэв барилгад галын бүслэвч байхгүй бол уг барилга, байгууламжийн гадна хашлага бүтээцээр талбайг тооцно.

3. ГУАТ-ийн төрөл, унтраах арга хэлбэр, гал унтраахад ашиглах бодисын сонголт зэргийг барилга байгууламжийн зориулалт, төлөвлөлт, технологийн онцлогоос хамааруулан хүчин төгөлдөр үйлчилж байгаа норматив баримт бичигт нийцүүлэн зураг төслийн байгууллага нь орон зайн төлөвлөлтийн үед Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцэн шийдвэрлэнэ.

3.1. Өрөө тасалгааны зориулалт, технологи, тэсэрч дэлбэрэх галын аюулын зэрэглэлээс хамааруулан зураг төслийн барилга архитектурын хэсгийн тодорхойлолтод гал унтраах системийн тэмдэглэгээ, ангиллыг хавсралт хүснэгтийн дагуу тусгасан байна.

Жагсаалтын 1 дүгээр хүснэгтийн 3, 5, 6.1, 7, 9, 10, 13 дугаар заалт, 3 дугаар

хүснэгтийн 14-19, 26-29, 32-38 дүгээр заалтад тусгагдсан барилга, өрөө тасалгаанд ГМДХ суурилуулах тохиолдолд утааны мэдээлэгчийг сонгоно.

Өрөө тасалгаа нь заагдсан хэмжээнээс бага бол бие даан ажиллах (автономный) гал унтраах төхөөрөмж – автомат гал унтраагуурыг 1 дүгээр хүснэгтийн 4.1.2, 4.2, 4.3, 8, 10-13; 2 дугаар хүснэгтийн 1, 2.1, 3.1, 4, 5.1; 3 дугаар хүснэгтийн 1-16, 17.1, 18.1, 19-23, 26, 27.1, 28, 29, 30, 31, 32, 33.2, 37, 38; 4 дүгээр хүснэгтийн 1-7 дахь заалтад тус тус төлөвлөнө.

Автомат гал унтраагуурыг сонгон хэрэглэхдээ Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөнө.

4. Энэ жагсаалтад заагдсан барилга, байгууламжид галын автомат тоног төхөөрөмжийг төлөвлөн суурилуулахдаа доор зааснаас бусад бүх өрөө тасалгааг талбайнаас үл хамааран хамгаалах шаардлагатай.

- ус чийгтэй орчин бүхий өрөө (усанд орох өрөө, узелийн өрөө, хөргөх камер, угаалгын өрөө г.м)

- шатамхай эд зүйл агуулаагүй агаар салхивчийн төхөөрөмжийн өрөө (үйлдвэрийн А, Б ангиллын өрөөнд хамааралгүй сорох болон өгөх агааржуулалтын), усан хангамжийн шахуургын өрөө, бойлерын ба бусад инженерийн техник, тоног төхөөрөмжийн өрөө

- гал түймрийн аюулын В4, Д ангиллын өрөө, тасалгаа

- шатны хонгил

5. Хэрэв ГУАТ-өөр тоноглох өрөө тасалгааны талбай нь барилгын давхрын нийт талбайн 40 болон түүнээс илүү хувийг эзэлж байвал 4 дүгээр заалтад зааснаас бусад бүх өрөө тасалгаанд ГУАТ тавина.

6. Өрөө тасалгаа, барилга байгууламжийн гал түймрийн аюулын ангилал, зэрэглэлийг галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичигт тусгасны дагуу тогтооно.

7. Тэсэрч дэлбэрэх аюултай бодис, материал ашигладаг технологийн тоног төхөөрөмжийг хамгаалах ГУАТ, автомат гал унтраагуур ба ГМДХ-г нормативын бичиг баримтад тусгайлан заасны дагуу төлөвлөн хийнэ.

8. Үүргийн галын аюулын Ф1, Ф2, Ф3, Ф4 ангийн авто зогсоолын битүү барилга нь энэ хавсралт ёсоор ГУАТ-тэй байх бол тэдгээрт ГМДХ нэмж суурилуулахаар төлөвлөх ёстой.

9. Хавсралтын 3 дугаар хүснэгтэд заагдсан өрөө, тасалгаа, 2 дугаар хүснэгтийн 11-д заагдсан байгууламж нь ямар зориулалтын барилгад байгаагаас үл хамааран галын автомат системээр тоноглогдоно.

10. Энэхүү хавсралтын хүснэгтэд хамаараагүй барилга байгууламж, өрөө тасалгааг галын аюулгүй байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр ямар төрлийн ГУАТ, автомат гал унтраагуур ба ГМДХ-ээр тоноглох эсэхийг шийдвэрлэнэ.

11. ГУАТ, автомат гал унтраагуур ба ГМДХ-ийг төлөвлөх, угсрах, засвар, техникийн үйлчилгээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын галын аюулгүй байдлын мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн барилгын асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд явуулна.

12. ГУАТ, ГМДХ тоноглогдсон барилга байгууламж нь техникийн боломжид тулгуурлан тухайн төв, орон нутгийн гал түймэр унтраах, аврах ангитай (гал гарсан тухай мэдээ хүлээн авах 101 дугаартай) холбоотой байхаар төлөвлөгднө.

13. ГУАТ, автомат гал унтраагуур ба ГМДХ-ээр заавал тоноглогдох барилга байгууламж, өрөө тасалгаа, тоног төхөөрөмжийн жагсаалтыг хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт №1

Барилга

Д/д	Хамгаалах объект	ГУАТ	ГМДТ
		Норматив үзүүлэлт	
1.	Галын аюулын В ангиллын 5,5м-ээс өндөр тавиуртай агуулах	Талбай, давхар хамаarahгүй	
2.	Галын аюулын В ангиллын 2 ба түүнээс дээш давхар агуулах (1 дүгээрт заалтад зааснаас бусад)	Талбайгаас хамаarahгүй	
3.	Архивын барилга (дахин давтагдашгүй үнэт зүйл, гар бичмэл, ном г.м.)	Талбайгаас хамаarahгүй	
4.	Авто тээврийн хэрэгслийн барилга, байгууламж Үүнд:		
4.1	Битүү авто зогсоол	Авто зогсоол Ангилал ба ерөнхий шаардлага MNS 5347:2007	
4.1.1.	Газар доорх болон дээрх 2 ба түүнээс дээш давхар зогсоол	≤10-аас дээш авто тээврийн хэрэгсэл	Талбайгаас хамаarahгүй
4.1.2.	Газар дээрх нэг давхар зогсоол		Талбайгаас хамаarahгүй
4.1.2.1	Гал тэсвэршилтийн I II III зэрэгтэй барилга	Барилгын (галаас хамгаалах бүсчлэл) нийт талбай 7000 м ² ба түүнээс их	7000 м ² хүртэл талбайтай автозогсоол
4.1.2.2	Гал тэсвэршилтийн IV зэрэгтэй, бүтээцийн галын аюулын С0 ангийн барилга	Барилгын (галаас хамгаалах бүсчлэл) нийт талбай 3600 м ² ба түүнээс их	3600 м ² хүртэл талбайтай авто зогсоол
4.1.2.3	Гал тэсвэршилтийн IV зэрэгтэй, бүтээцийн галын аюулын С1 ангийн барилга	Барилгын (галаас хамгаалах бүсчлэл) нийт талбай 2000 м ² ба түүнээс их	2000 м ² хүртэл талбайтай авто зогсоол
4.1.2.4	Гал тэсвэршилтийн IV зэрэгтэй, бүтээцийн галын аюулын С2, С3 ангийн барилга	Барилгын (галаас хамгаалах бүсчлэл) нийт талбай 1000 м ² ба түүнээс их	1000 м ² хүртэл талбайтай авто зогсоол
4.1.3.	Механиюксан авто зогсоол	Талбай, давхар хамаarahгүй	
4.2.	Ил задгай авто зогсоолын барилга		Талбай, давхар хамаarahгүй
4.3.	Авто техникийн засвар, үйлчилгээ		Талбай, давхар хамаarahгүй

5.	30 м-ээс дээш өндөртэй барилга (орон сууц болон үйлдвэрийн галын аюулын Г, Д ангилалын барилгаас бусад төрлийн барилга)	Талбайгаас хамаarahгүй	
6.	Орон сууцны барилга		
6.1.	Дотуур болон нийтийн зориулалттай байр, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан		Талбайгаас хамаarahгүй
6.2.	75м-ээс дээш өндөртэй орон сууц	Талбайгаас хамаarahгүй	
6.3.	28м-ээс дээш өндөртэй орон сууц		Талбайгаас хамаarahгүй
7.	Шатамхай полимер дүүргэгчтэй хөнгөн металл бүтээцтэй 1 давхар барилга:		
7.1.	Олон нийтийн зориулалттай үйлчилгээний барилга	800 м ² ба түүнээс их талбайтай	800 м ² -аас бага талбайтай
7.2.	Захиргаа аж ахуйн зориулалттай	1200 м ² ба түүнээс их талбайтай	1200 м ² -аас бага талбайтай
8.	Үр тариа хадгалах, боловсруулах барилга, байгууламж		Талбайгаас хамаarahгүй
9.	Олон нийтийн ба захиргаа-аж ахуйн зориулалтын барилга (11, 13 дэх заалтаас бусад)		Талбай, давхраас хамаarahгүй
10.	Худалдаа үйлчилгээний барилга байгууламж (4 дүгээр заалтад зааснаас бусад болон шатдаггүй барилгын материал, төмөр сав, суулга, мөн мах, махан бүтээгдэхүүн, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ (шатдаггүй баглаа боодолтой) хадгалах, бэлтгэх өрөөнөөс бусад)		
10.1	1 давхар барилга (13 дэх заалтаас бусад)		
10.1.1	Худалдааны болон аж ахуйн туслах өрөө байр нь газрын доорх давхар, хагас давхарт байрласан	200 м ² ба түүнээс их талбайтай	200 м ² -аас бага талбайтай
10.1.2.	Худалдааны болон аж ахуйн туслах өрөө байр нь барилгын газрын дээрх хэсэгт байрласан	3500 м ² ба түүнээс их талбайтай	3500 м ² -аас бага талбайтай
10.2.	2 давхар барилга:		
10.2.1.	Худалдааны нийт талбай	3500 м ² ба түүнээс их	3500 м ² -ээс бага
10.2.2.	Худалдааны танхим нь газрын доорх болон хагас давхарт байрласан	Талбайгаас хамаarahгүй	
10.2.3.	3 давхар ба түүнээс дээш	Талбайгаас хамаarahгүй	
10.2.4.	Хялбар авалцан асах шатамхай эд зүйл ба шатамхай бодис материал борлуулдаг тусгай дэлгүүр (20 л-ээс бага хэмжээгээр савласан жижиглэнгийн бараанаас бусад)	Талбайгаас хамаarahгүй	
11.	Шатахуун түгээх станц болон түүнд хамаарах худалдаа үйлчилгээний байрууд	ШТС-ын галын аюулгүйн норм ба дүрэмд заасны дагуу	

12.	Шашны байгууллагын барилга (шашны цогцолборын харьяа үйлдвэр, агуулах, орон сууцны барилгын галын автомат системийг БНБД 21-04-05-ын холбогдох заалтад зааснаар төлөвлөнө)		Талбай, давхраас хамаarahгүй
13.	Үзэсгэлэнгийн танхимууд:		
13.1.	1 давхар (12 дахь заалтад зааснаас бусад)	1000 м ² ба түүнээс их талбайтай	1000 м ² -ээс бага талбайтай
13.2.	2 ба түүнээс дээш давхар	Талбай хамаarahгүй	

1) ГУАТ-ийн спринклерийн хошууг өрөөний гол үүдний орох хэсгийн дээр ба нийтийн хонгилд байрлуулна.

Хүснэгт №2

Байгууламж

д/д	Хамгаалах объект	ГУАТ	ГМДХ
		Норматив үзүүлэлт	
1.	Цахилгаан станцын кабелийн байгууламж	Талбайгаас хамаarahгүй	
2.	Дэд станцын кабелийн байгууламж, кВ:		
2.1.	500 ба түүнээс их кВ	Талбайгаас хамаarahгүй	
2.2.	500-аас бага кВ		Талбайгаас хамаarahгүй
3.	110кВ-220 кВ-ын хуваарилах дэд станцын кабелийн байгууламж, трансформаторын чадал нь: МВА		
3.1.	63 ба түүнээс их МВА	Талбайгаас хамаarahгүй	
3.2.	63 –аас бага МВА		Талбайгаас хамаarahгүй
4.	Үйлдвэрийн болон олон нийтийн барилгын кабелийн байгууламж	100 м ³ –с их	100 м ³ ба түүнээс бага
5.	220, түүнээс их В-ын кабель, шугам татсан үйлдвэрийн болон олон нийтийн барилгын нийлмэл сувагт:		
5.1.	100 м ³ –ээс их эзлэхүүнтэй	12 ба түүнээс олон ширхэг	5-12 ширхэг
5.2.	100 м ³ ба түүнээс бага эзлэхүүнтэй		5 ба түүнээс олон ширхэг
6.	Үйлдвэрийн барилгуудын хооронд татсан кабелийн суваг, бүрэн битүүмжлэгдсэн галерей (мөн хосолмол)		50 м ³ ба түүнээс их
7.	Хотын кабелийн хонгил ба суваг (мөн хосолмол)		Талбай, эзлэхүүнээс хамаarahгүй
8.	Төмөр хоолойд сүвэлсэн тос дүүргэмэл кабелийг кабелийн байгууламжид байрлуулах		Талбай, эзлэхүүнээс хамаarahгүй
9.	Хялбар авалцан асах болон шатамхай шингэн хадгалах ил сав (резервуар)	5000 м ³ ба түүнээс их	
10.	Модон материал тээвэрлэх зориулалттай эстакад, хаалттай		Уртаас үл хамаarahгүй

	галерей		
11.	Ш1-Ш4 бүлгийн шатдаг материалаар тусгаарлагдсан агааржуулалтын ба бусад шугам хоолой, тэрчлэн галын аюулын ПРГП1 код бүхий ШҮ ангиллын кабель, цахилгааны утас татсан (мөн тэдгээрийг хамт тавьсан) дүүжин таазны хөндий ба давхар шал хоорондын зайд)		
11.1.	Агааржуулалтын хоолой, хамгаалалтын хоолой болон кабелийн шугам хамт байрласан, шугамын тоо 12, хүчдэл 220кВ түүнээс дээш	Талбай, эзлэхүүнээс хамаarahгүй	
11.2.	Кабель шугамын тоо 12 хүртэл, хүчдэл 220кВ түүнээс дээш кабелийн шугамын ШҮ төрлийн кабелийн суваг		Талбай, эзлэхүүнээс хамаarahгүй
12.	Авто замын хонгил	Холбогдох БНБД-ээр зохицуулагдана	

* кабелийн байгууламж гэж цахилгааны шугам тавих хонгил, суваг, газар доорх давхар, босоо хоолой, давхар шал, галерей, камерыг ойлгоно.

** кабелийн байгууламж, давхар шал, дүүжин таазны хоорондох зайд гол унтраах автомат төхөөрөмж сууринуулахгүй

Хүснэгт №3

Өрөө тасалгаа

Д/д	Хамгаалах объект	ГУАТ	ГМДХ
		Норматив үзүүлэлт	
Агуулахын зориулалттай өрөө тасалгаа			
1.	Тэсэрч шатах галын аюулын А , Б ангиллын өрөө тасалгаа (үр тариа хадгалах, боловсруулах барилгад байгаагаас бусад)	300 м ² ба түүнээс их	300 м ² -аас бага
2.	Каучук, цеплуюид болон түүгээр хийсэн эд зүйл, шүдэнз, шүлтлэг металлууд, пиротехникийн хэрэгсэл	Талбайгаас хамаarahгүй	
3.	Арьс шир, түүгээр хийсэн эд зүйл, нягт багтай шатамхай зүйлс (шатамхай суурьтай кино, видео, дуу хураагуурын хальс)	Талбайгаас хамаarahгүй	
4.	Галын аюулын В1 ангиллын өрөө тасалгаа (2, 3 дахь заалтад орсон болон үр тариа хадгалах, боловсруулах барилгад байгаагаас бусад) барилгын давхруудад байрласан бол:		
4.1.	Зоорийн болон хагас зоорийн давхарт	Талбайгаас хамаarahгүй	
4.2.	Газар дээрх давхарт	300 м ² ба түүнээс их	300 м ² -аас бага
5.	Галын аюулын В2 – В3 ангиллын өрөө тасалгаа (2, 3 дахь заалтад орсон болон үр тариа хадгалах, боловсруулах барилгад байгаагаас бусад) барилгын давхруудад байрласан бол:		

5.1.	Зоорийн болон хагас зоорийн давхарт	300 м ² ба түүнээс их	300 м ² -аас бага
5.2.	Газар дээрх давхарт	1000 м ² ба түүнээс их	1000 м ² -аас бага

Үйлдвэрийн зориулалттай өрөө тасалгаа

6.	Тэсэрч шатах галын аюулын А, Б ангиллын өрөө (11 дэх заалтад заасан болон үр тариа хадгалах, боловсруулах барилгад байгаагаас бусад). Шатамхай хий (шингэрүүлсэн хийнээс бусад) ашигладаг А ангиллын үйлдвэрийн өрөөг хэрэглэж буй шатамхай хийн хэмжээг тооцоогүй галын ачааллаас хамааран ГУАТ-ыг сонгон сууринуулах ба мөн ГМДХ-ээр хамгаална.	300 м ² ба түүнээс их	300 м ² - аас бага
7.	Шүлтлэг металл хэрэглэх өрөө тасалгаа төлөвлөх:		
7.1.	Хагас зоорийн давхарт	300 м ² ба түүнээс их	300 м ² -аас бага
7.2.	Газар дээрх давхарт	500 м ² ба түүнээс их	500 м ² - аас бага
8.	Галын аюулын В1 ангиллын өрөө тасалгаа: (үр тариа хадгалах, боловсруулах барилгад байгаагаас бусад)		
8.1.	Зоорийн болон хагас зоорийн давхарт	Талбайгаас хамаарахгүй	
8.2.	Газар дээрх давхарт (11-18 дугаар заалтад зааснаас бусад)	300 м ² ба түүнээс их	300 м ² -аас бага
9	Галын аюулын В2 – В3 ангиллын өрөө тасалгаа: (10-18 дугаар заалтад заасан ба үр тариа хадгалах, боловсруулах барилгад байгаагаас бусад)		
9.1.	Зоорийн болон хагас зоорийн давхарт		
9.1.1.	Гадагш шууд гарах гарцгүй	300 м ² ба түүнээс их	300 м ² -аас бага
9.1.2.	Гадагш шууд гарах гарцтай	700 м ² ба түүнээс их	700 м ² -аас бага
9.2.	Газар дээрх	1000 м ² ба түүнээс их	1000 м ² -аас бага
10.	Зоорийн тосны агуулах өрөө	Талбайгаас хамаарахгүй	
11.	Бэлтгэлийн өрөө: шингэн халиман цавуу, хөнгөн цагааны бургидас; Хялбар авалцан асах ба шатамхай шингэн суурьтай: будаг, лак, каучук, цавуу, нэвчилгээний бодис, түрхлэг, будгийн өрөө, нийлэг каучукын боловсруулалт, хийн трубины компрессорын өрөө, газрын тос халаах өрөө, шингэн түлшээр ажилладаг хөдөлгүүртэй генераторын өрөө	Талбайгаас хамаарахгүй	
12.	Өндөр вольтын туршилтын танхим, шатдаг материалын шинжилгээний өрөө, тасалгаа	Талбайгаас хамаарахгүй	

Холбооны өрөө

13.	Агаар сэлгэлтийн төхөөрөмжийн өрөө, трансформаторын өрөө, хуваарилах байгууламжийн өрөө, 150 кВт ба түүнээс их чадалтай дамжуулагчтай		Талбайгаас хамаарахгүй
-----	---	--	------------------------

	радиостанц, 20 –иос их харилцагчтай хүлээн авах радиостанц, 1 кВт-аас их чадалтай дамжуулагчтай сансрын холбоо, 25-50 кВт чадалтай дахин дамжуулах зурагтын станц, хот хоорондын холбооны станц, холбооны узель, төгсгөлийн цэг		
--	---	--	--

Объектын хамгаалалт

14.	Үйлчилгээтэй ба үйлчилгээгүй, оройн болон шөнийн ээлжгүй: завсрын радио реле, хүчинтгэлийн цэгийн техникийн цех, дамжуулах хүлээн авах радио төв	Талбайгаас хамаarahгүй	
15.	Хөдөлгөөнт радио холбоо, гар утасны удирдлагын төвийн үйлчилгээгүй өрөө байр, радиорелений аппаратын өрөө	24 м ² ба түүнээс их	24 м ² -аас бага
16.	Шуудан холбооны станцын удирдлагын байр, тооцооны төв		
16.1.	40 мянган м ³ ба түүнээс их	24 м ² ба түүнээс их	24 м ² -аас бага
16.2.	40 мянга м ³ -ээс бага		Талбайгаас хамаarahгүй
17.	Холбооны харилцах танхим, утсан холбооны удирдлагын болон тооцоолон бодох төв, станцын өрөө		
17.1.	10 мянга ба түүнээс их дугаарт үйлчлэх суваг	Талбайгаас хамаarahгүй	
17.2.	10 мянга ба түүнээс бага дугаарт үйлчлэх суваг		Талбайгаас хамаarahгүй
18	Хот хоорондын холбооны удирдлагын өрөө, тооцоолох төв		
18.1.	Хот хоорондын 10 мянга ба түүнээс их дугаарт үйлчлэх суваг	24 м ² ба түүнээс их	24 м ² түүнээс их
18.2.	Хот хоорондын 10 мянгаас бага дугаарт үйлчлэх суваг		Талбайгаас хамаarahгүй
19.	Холбооны салбарын илгээлт, захидал шуудан, хэвлэлийн тасаг	500 м ² ба түүнээс их	500 м ² -аас бага

Тээврийн байгууллагын өрөө, тасалгаа

20.	Галт тэрэгний засвар үйлчилгээний төв: (цахилгаан машины, тэргэнцэр, дугуйны, вагон задаргааны, цахилгаан тэжээлийн хөдөлгүүрийн, хөдөлгөөнт хэсгийн түлшний үйлчилгээний, хатаалга, халуунаар хатаах ажиллагаа явуулах чингэлэгт депо, г.м)	Талбайгаас хамаarahгүй (Холбогдох БНБД)	
21.	Газар доогуурх төмөр болон авто замын байгууламжийн өрөө, тасалгаа	(Холбогдох БНБД)	
22.	Зам тээврийн хэрэгслийн удирдлага зохицуулалт хяналтын өрөө	Талбайгаас хамаarahгүй	
23.	Нисэх онгоц, нисдэг тэрэгний сэнс, дугуй, явах эд ангид засвар, үйлчилгээ хийх байр	Талбайгаас хамаarahгүй	
24.	Нисэх онгоц ба онгоцны хөдөлгүүрийн үйлдвэрлэлийн (угсрал) өрөө	Талбайгаас хамаarahгүй	
25.	Тээврийн хэрэгслийг зориулалтын бус байранд (хувийн орон сууцнаас бусад) хадгалах бол:		

25.1.	Газар доорх болон зоорийн давхарт (мөн гүүрний доор)	Талбайгаас хамаarahгүй	
25.2.	Хагас зоорийн болон газар дээрх давхруудад	3 ба түүнээс их автомашин хадгалдаг	3-аас бага автомашин хадгалдаг
Олон нийтийн өрөө тасалгаа			
26.	Хосгүй үнэт дурсгал, ном хэвлэл, гар бичмэл, баримт бичиг (мөн өвчтөний хагалгааны түүх) хадгалах өрөө	Талбайгаас хамаarahгүй	
27.	Архив, номын санд тусгай өрөөнд хадгалах албан баримт бичиг		
27.1.	500 мянга нэгж ба түүнээс их	Талбайгаас хамаarahгүй	
27.2.	500 мянгаас бага нэгжтэй		Талбайгаас хамаarahгүй
28.	Үзэсгэлэнгийн танхим*	1000 м ² ба түүнээс илүү	1000 м ² -аас бага
29.	Музейн үнэт үзмэр хадгалах өрөө	Талбайгаас хамаarahгүй	
30.	Соёл үзвэрийн газар	Талбай хамаarahгүй	
31	Үнэт эд зүйл, мөнгөн тэмдэгт хадгалах өрөө		
31.1.	Банк ба банк бус санхүүгийн байгууллага	Талбайгаас хамаarahгүй	
31.2.	Барьцаалан зээлдүүлэх газар (Ломбард)	Талбайгаас хамаarahгүй	
32.	Кино зураг авалтын тусгай танхим	1000 м ² ба түүнээс их	1000 м ² -аас бага
33.	Гар ачаа тээш хадгалах өрөө (автомат удирдлагатай хайрцган хадгаламжаас бусад) болон галт тэрэгний буудал (нисэх онгоцны буудал) дахь шатдаг эд зүйлийн агуулах:		
33.1.	Зоорийн ба хагас зоорийн давхар	Талбайгаас хамаarahгүй	
33.2.	Газар дээрх давхар	300 м ² ба түүнээс их	300 м ² -аас бага
34.	Шатдаг болон шатдаггүй материал, шатдаггүй боодол баглаатай эд зүйл хадгалах өрөө:		
34.1.	Спортын битүү цогцолборын (суудлын тоо хамаarahгүй) үзэгчдийн тавцан суудал дор	100 м ² ба түүнээс их	100 м ² -аас бага
34.2.	800-аас дээш суудалтай спортын битүү цогцолборын барилгад	100 м ² ба түүнээс их	100 м ² -аас бага
34.3.	3000 түүнээс их суудалтай спортын задгай цэнгэлдэх хүрээлэнгийн тавцан суудал дор	100 м ² ба түүнээс их	100 м ² -аас бага
35.	Техник хангамжийн өрөө:		
35.1.	Тооцоолон бодох төв, Удирдлага холбооны өрөө зэрэг үйл ажиллагааны доголдол нь хүний аюулгүй байдалд нэлөөлэхүйц онцгой өрөө, тасалгаа	Талбайгаас хамаarahгүй	
35.2.	Удирдлагын сервер, дуу хадгалах соронзон туузууд, хэвлэх төхөөрөмжүүдийн өрөө	24 м ² ба түүнээс их	24 м ² -аас бага

35.3.	Үйлчлүүлэгчийн хэрэглээний тооцоолон бодох машины өрөө		Талбайгаас хамаarahгүй
36.	Өөр зориулалтын барилга дотор байрлуулсан, эсвэл залгаж өргөтгөн барьсан худалдааны зориулалттай өрөө тасалгаа:		
36.1.	Зоорийн ба хагас зоорийн давхар	200 м ² ба түүнээс их	200 м ² -аас бага
36.2.	Газар дээрх давхрууд	500 м ² ба түүнээс их	500 м ² -аас бага
37.	Үүргийн галын аюулын Ф1.1, Ф4.1 ангийн барилгад байгаа үйлдвэрийн ба агуулахын зориулалттай гол түймрийн аюулын В4 ангиллын өрөө		Талбайгаас хамаarahгүй
38.	Захиргааны, захиргаа – аж ахуйн ба олон нийтийн зориулалтын өрөө тасалгаа (өөр барилгад залгаж барьсан, оруулж байрлуулсан)		Талбайгаас хамаarahгүй

Хүснэгт №4

Тоног төхөөрөмж

д/д	Хамгаалах объект	ГУАТ	ГМДХ
		Норматив үзүүлэлт	
1.	Хялбар авалцан асах шингэн, шатамхай шингэн хэрэглэх будгийн өрөө	Төрлөөс хамаarahгүй	
2.	Хатаалгын өрөө	Төрлөөс хамаarahгүй	
3.	Шатамхай хог хаягдлын өрөө	Төрлөөс хамаarahгүй	
4.	Хүчиний тосон трансформатор ба реактор		
4.1.	500 кВ ба түүнээс дээш хүчдэлтэй	Чадлаас үл хамаарна	
4.2.	220-330 кВ ба түүнээс дээш хүчдэлтэй	200 мВА түүнээс дээш	
4.3.	Нэгж хүчдэл бүхий усан цахилгаан станцын барилгын дэргэд байрлуулсан 110 кВ хүчдэлтэй	63 мВА түүнээс дээш	
4.4.	Усан цахилгаан станц ба дэд станцын хаалттай хуваарилах төхөөрөмжид болон хуваарилах хаалттай дэд станцын камерт байршуулах 110 кВ ба түүнээс дээш хүчдэлтэй	63 мВА түүнээс дээш	
5.	Түлш болон бензинээр ажиллах чиргүүл, машинд байрлуулсан зөөврийн цахилгаан станцын тоног төхөөрөмжийн туршилтын явуулын станц	Талбайгаас хамаarahгүй	
6.	Шатамхай болон шатамхай боодол баглаатай үл шатах материал эд зүйл хадгалж хураах 5,5м-ээс дээш өндөртэй тавиурууд	Талбайгаас хамаarahгүй	
7.	Хатаах зориулалтын тосны сав	3 м ³ түүнээс их	

Эдгээр хэрэгслийг (тоног төхөөрөмжийг) бие даан ажиллах (автономный) гол унтраах төхөөрөмж – автомат гол унтраагуураар хамгаалах ёстой.